

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

## ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМАНД


Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн хуралдааны 52 дугаар тэмдэглэлд:

“ХҮ1.4. Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлж, Засгийн газрын 2016 оны 219 дүгээр тогтоолын дагуу төсвийн ерөнхийлөн захирагч, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланд тусгасан зээлийн хөрөнгийн талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:

1. Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлж, Засгийн газрын 2016 оны 219 дүгээр тогтоолоор Засгийн газарт шилжүүлсэн нийт 3.184 (гурван их наяд нэг зуун наян дөрвөн тэрбум) тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 348 төсөл, арга хэмжээнээс өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалт, төсөвт өртөг, хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэсэн ажлын чанар, хэрэгжилт болон хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлсэн эсэх байдалд нарийвчилсан хяналт шалгалт хийхийг холбогдох сайд нар болон Нийслэлийн Засаг дарга С.Батболдод даалгав.

2. Шалгалтын мөрөөр зохих арга хэмжээ авч хэрэгжүүлэн дүнг 2018 оны 2 дугаар сард багтаан Засгийн газарт танилцуулахыг Монгол Улсын Шадар сайд Ө.Энхтүвшин, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзориг, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн, Нийслэлийн Засаг дарга С.Батболд болон “Эрдэнэс Оюу толгой” ХХК-д тус тус даалгав.

3. Монгол Улсын Хөгжлийн банкнаас хувийн хэвшлийн аж ахуйн нэгж болон төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагад арилжааны нөхцөлтэй олгосон 2.9 их наяд төгрөгийн зээлийн санхүүжилт холбогдох хууль тогтоомж, журмын хүрээнд хэрэгжсэн эсэх байдлыг нарийвчлан шалгаж, шаардлагатай бол зохих хууль хяналтын байгууллагад хандах, банкнаас олгосон нийт зээлийн эргэн төлөлтийг эрчимжүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал Б.Батбаярт даалгав.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР